



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/292

Булган сум

**Сэлэнгэ сумын Ерөнхий боловсролын сургууль,
Цэцэрлэгт дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” 25 дугаар тогтоол, 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” 90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлэнгэ сумын Засаг даргын тамгын газраас хүсэлт гаргасны дагуу Ерөнхий боловсролын сургуульд хөгжмийн тоног төхөөрөмж худалдан авахад 5,000,000 (таван сая) төгрөг, Цэцэрлэгт ухаалаг дэлгэц худалдан авахад 8,000,000 (найман сая) төгрөгийн санхүүжилтийг олгож, төсвийн тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010397

Сууга Ажил 2026 өдөр Бvр Doc/2026/Захирамж

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 20 нынний өдрийн
А/298 дугаар захирамжийн хавсралт



ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ ТӨСВИЙН ЗАРДАЛ

д/д	Байгууллагын нэр	Тоног төхөөрөмжийн нэр	Зардал, төгрөг
1	2	3	4
1	Сэлэнгэ сумын Ерөнхий боловсролын сургууль	Хөгжмийн тоног төхөөрөмж	5,000,000
2	Сэлэнгэ сумын Цэцэрлэг	Ухаалаг дэлгэц	8,000,000
		Нийт дүн	13,000,000

--o00o--